



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
БОЛОВСРОЛЫН ГАЗАРТ

**БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ
ИНСТИТУТ**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 10
Багшийн хөгжлийн ордон
Утас/Факс: (976) 7014-0069. www.itpd.edu.mn

2015. 04. 14 № 1/132

танай _____-ны № _____-т

Онлайн бүртгэлийн тухай

Эхний жилдээ ажиллаж буй багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад оролцох багш нарын онлайн бүртгэлийг 2015 оны 04 дүгээр сарын 23-наас 28-ны өдрүүдэд дахин нээж байгааг мэдэгдэж байна. Та бүхэн энэ хугацаанд:

1.Онлайн бүртгэлд өмнө бүртгэгдсэн багш нарт хувийн мэдээллээ хянаж, алдаатай мэдээллээ засварлах тухай мэдэгдэх

2.Бүртгэлээс хоцорсон багш нарыг нэмж бүртгүүлэх ажлыг хариуцлагатай зохион байгуулна уу.

Өмнө бүртгэгдсэн багш нарын дотор:

1. Хувийн мэдээллээ буруу оруулсан /регистр, аймаг, сум, овог нэр, төгссөн он, мэргэжил/
2. Сургалтад хамрагдах жилийн ангиллаа буруу сонгосон
3. Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар оруулаагүй
4. Сургууль, ажлын газраа буруу оруулсан буюу оруулаагүй
5. Нэгээс илүү жил ажилласан
6. Багшаар ажиллах эрхийн шалгалтад ороогүй буюу тэнцээгүй
7. Багшаар ажиллах эрхийн үнэмлэхийн дугаар оруулаагүй зэрэг алдаанууд байгаа тул бүртгэлийг дахин хянаж бүртгэлээс хоцорсон багш нар дахин бүртгүүлэх боломж олгож байгаа болно.

<http://burtgel1.itpd.mn/> хаягаар зөвхөн эхний жилдээ ажиллаж буй багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах багш нарт зориулан хийгдэж байгаа бөгөөд онлайн бүртгэлээс мэдээллээ үнэн зөв, бүрэн оруулсан, сургалтад хамрагдах шаардлага хангасан багш нарын нэрсийг татан авч сургалтад хамруулах болно.

Жич: Бүртгэлд мэдээллээ дутуу буюу буруу оруулснаас шалтгаалж сургалтад хамрагдах боломжгүй болох тохиолдол гарч байгааг анхаарна уу.

Онлайн бүртгэлд бүртгүүлэх буюу хувийн мэдээллээ засварлах зааварчилгааг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: Онлайн бүртгэлд бүртгүүлэх буюу хувийн мэдээллээ засварлах зааварчилгаа хуудастай

ЗАХИРАЛ

Г.СҮГЛЭГМАА



PC2\ID:\Албан бичиг\Явсан Бичиг 2015\A4.docx

02 000086

Онлайн бүртгэлд бүртгүүлэх буюу хувийн мэдээллээ засварлах зааварчилгаа

Эхний жилдээ ажиллаж буй багш нарын үндсэн сургалтын бүртгэлд <http://burtgel1.itpd.mn/> хаягаар зөвхөн дараах багш нар бүртгүүлэхийг анхаарна уу.

Үүнд:

1. 2013 оны 09 дүгээр сарын 01-нээс 2013 оны 12 дугаар сарын 31-ны хооронд сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн багш, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн ерөнхий эрдмийн багшаар ажиллаж эхэлсэн бөгөөд 2014 онд эхний жилдээ ажиллаж буй багшийн үндсэн сургалтад хамрагдаагүй багш нар
2. 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн багш, мэргэжлийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн ерөнхий эрдмийн багшаар ажиллаж эхэлсэн, багшаар ажиллах эрхийн үнэмлэхтэй багш нар

Онлайн бүртгэлийн системд дараах зааврын дагуу нэвтэрч, бүртгүүлэх буюу мэдээллээ засварлана.

1. Өмнө бүртгүүлсэн багш нар хувийн мэдээллээ хянах, засварлах

Өмнө нь <http://burtgel.itpd.mn/> хаягаар бүртгүүлсэн багш нарын мэдээллийг <http://burtgel1.itpd.mn/> -д байршуулсан байгаа болно. Иймд мэдээллээ хянах буюу засварлах шаардлагатай бол <http://burtgel1.itpd.mn/> хаягаар орж нэвтрэх хэсэгт e-mail хаяг болон нууц үгээ ашиглан нэвтэрнэ.



/Бүртгүүлсэн нэр болон нууц үгээ мартсан бол БМДИ, Л.Номиндарь /97112071/-тай ажлын цагаар холбогдон асуух/

Нэвтрэн орсноор дараах хэсэг харагдах ба багш өөрийн оруулсан мэдээллүүдээ дахин хянаж, бөглөгдөөгүй үлдсэн эсвэл буруу оруулсан хэсэг байгаа эсэхийг хянан, шаардлагатай бол **МЭДЭЭЛЛИЙГ ЗАСВАРЛАХ** товчийг даран мэдээллийг засварлана.

ОНЛАЙН БҮРТГЭЛ ШАЛГАЛТЫН СИСТЕМД ТАВТАЙ МОРИЛНО УУ !

Хувийн мэдээлэл	ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ			
Системээс гадах	Урьийн овог:	Бүрхлэг:	Овог нэр:	Гансуу:
	Регистрийн дугаар:	МҮЭН112	Хүйс:	Эм
	Иргэншил:	МОНГОЛ	Утас:	995011
	Аймаг, нийслэл:	Төв	Сум, дүүрэг:	Мянгансүрэг
	Ангилал:	ЕБС		
	БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЭЛ			
	Төгссөн сургууль:	МҮЭНС-БС	Төгссөн он:	2014
	Боловсролын зэрэг:	Багшаар	Дипломын дугаар:	D201422414
	Багшаар ажиллаж эрхийн үнэмлэхийн дугаар:		Багшаар эрхийн үнэмлэхийн дугаар:	
	Мэргэжлийн зэрэг:	Мэргэжлийн зэрэг байхгүй	Мэргэжлийн зэргийн үнэмлэхийн дугаар:	
	Мэргэжлийн зэрэг авсан огноо:	0		
	Сургалтад хамрагдах мэргэжил:	Альбан бус боловсролын багш	Сургалтад хамрагдах ангилал:	Эхний хэлдэг
	АЖИЛ ЭРХЛЭЛТ			
	Аймаг, нийслэл:	Төв	Сум, дүүрэг:	Мянгансүрэг
	Одоо ажиллаж буй албан байгууллага:	Сургууль	Одоо ажиллаж буй аллын нэр:	Мянгансүрэг ЕБС
	Одоо ажиллаж буй албан тушаал:	Альбан бус боловсролын багш	Сургууль, Цэцэрлэг, Алдасгарах яамал:	1
	Багшаар ажиллаж буй жил:	1	Нийт Боловсролын сайбар ажилласан жил:	1

Та өөрийн хувийн мэдээллийг үнэн зөв оруулсан эсэхийг сайтар шалгах явдальтай бол доорх мэдээллийг засварлах товч дээр дарж үнэн зөв оруулна уу!

МЭДЭЭЛЛИЙГ ЗАСВАРЛАХ

2015.03.14-ний өдрийн багшлах эрхийн шалгалтад тэнцсэн, багшаар ажиллаж буй иргэд багшлах эрхийн үнэмлэхний дугаар хэсэгт 03.14 гэж оруулахыг анхаарна уу. Мөн нийгмийн даатгалын дэвтрээ бүрэн эхээр нь сканнердаж оруулсан байх шаардлагатай.

2. Системд шинээр бүртгүүлэх

Шинээр бүртгүүлэх багш нар **бүртгүүлэх** товчийг дарахад дараах цонх гарч ирэх ба багш бүх мэдээллээ оруулж, нийгмийн даатгалын дэвтрээ сканнердаж оруулна.

 БОЛОВСРОЛ, УНДГАЙН ХААГААГА УЛААНБААТАР	 СЭЛЭГЭЙН ХААГААГА ДЭДЭВЛЭХ ИСТИТУТ	Нүүр хуудас Бүртгүүлэх Нэвтрэх
ОНЛАЙН СУРГАЛТЫН БҮРТГЭЛИЙН СИСТЕМД ТАВТАЙ МОРИЛНО УУ !		

Бүх мэдээллийг үнэн зөв оруулсны дараа **БҮРТГҮҮЛЭХ** товчийг даран мэдээллийг илгээнэ.

Хэрэв таны мэдээлэл бүртгэлийн системд илгээгдсэн бол дараах цонх гарч ирэх болно.

Онлайн сургалтын бүртгэлийн системд амжилттай бүртгэгдлээ.
Та бүртгүүлсэн имэйл хаяг болон нууц үгээ ашиглан өөрийн мэдээллийг шалгах боломжтой.
Танд амжилт хүсье!

Бүртгэлийн системд бүртгүүлэх зааварчилгааг видео хэлбэрээр <http://burtgel1.itpd.mn/>-д байршуулсан болно.

